



ДОРНОД АЙМГИЙН ОНЦГОЙ КОМИССЫН  
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

2021 оны 09 дүгээр сарын 07 өдөр

Дугаар 80

Хэрлэн сум

LXXX ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

Аймгийн Онцгой комиссын 80 дугаар хуралдаан 2021 оны 09 дүгээр сарын 07-ны өдрийн 09:00 цагт танхимаар 64,5 хувийн ирцтэй хуралдав.

Хуралдааныг аймгийн Засаг дарга, Онцгой комиссын дарга М.Бадамсүрэн даргалж холбогдох үүрэг даалгаврыг өгөв.

СОНССОН НЬ:

1.Коронавируст халдвар (Ковид-19)-ын нөхцөл байдлын талаарх мэдээллийг танилцуулах,

*Аймгийн ерөнхий тархвар судлаач*

2.Түргэвчилсэн шинжилгээний нөхцөл байдал, хамрагдалт, зохион байгуулалтын арга хэмжээний талаар танилцуулах,

*Аймгийн ерөнхий тархвар судлаач*

3.Коронавирус болон томуугийн эсрэг дархлаажуулалтын явц, авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаарх мэдээлэл танилцуулах,

*Эрүүл мэндийн газар*

4.Сургууль, цэцэрлэгийн үйл ажиллагаа эхэлсэнтэй холбогдуулан нөхцөл байдлын талаарх мэдээлэл, санал танилцуулах,

*Боловсрол, соёл урлагийн газар*

*Эрүүл мэндийн газар*

5.Үхрийн арьс товруутах өвчний нөхцөл байдлын талаарх мэдээлэл танилцуулах,



*Мал эмнэлгийн газар*

6.Зээрийн тандалтын талаарх мэдээллийг танилцуулах.

*Байгаль орчин, аялал жуулчлалын газар*

7.Улсын онцгой комиссын нарийн бичгийн даргын албан бичиг танилцуулах, нийтийг хамарсан арга хэмжээг хориглосон тухай тогтоолыг хэлэлцэх, тогтоолын төсөл танилцуулах,

*Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газар*

/  / М.Бадамсүрэн  
/  / х/ч Б.Цогтбаяр

8.Иргэд, аж ахуйн нэгж байгууллагаас аймгийн Онцгой комисст ирүүлсэн хүсэлт танилцуулах,

*Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газар*

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

Нэг.Эрүүл мэндийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн Ч.Оюунаа,

Бүсийн оношлогоо эмчилгээний төвийн захирал, Онцгой комиссын гишүүн Д.Должин нарт:

1.1.Коронавируст халдвар /Ковид-19/-ын эмчилгээний талаар олон нийтэд сурталчлах ажлыг зохион байгуулах,

1.2.Коронавируст халдвар /Ковид-19/ илрүүлэх шинжилгээг ойрын хавьтлын 6 дахь хоногт шинж тэмдэгтэй тохиолдолд шинж тэмдэг илрүүлэх зорилгоор иргэдээс шинжилгээг авах,

1.3.Тандалтын шинжилгээг 60-аас дээш насныхан, жирэмсэн, шинж тэмдэгтэй буюу эрсдэлтэй иргэдээс үнэ төлбөргүй авах,

1.4.Оюутан, сурагчдын дотуур байр, хорих газар, эрүүлжүүлэх баривчлах байр, асрамжийн газар, цэргийн анги, уул уурхай, газрын тосны аж ахуйн нэгжийг түшиглэсэн тандалт шилжилгээг зохион байгуулах,

1.5.Вакцингүй бүлэг буюу 5-11 насны хүүхдүүдийг томуугийн вакцинд хамруулах ажлыг 1 сарын хугацаанд хийх талаар олон нийтэд сурталчлах ажлыг зохион байгуулах,

Эрүүл мэндийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн Ч.Оюунаа,

Хэрлэн сумын Засаг дарга бөгөөд Чойбалсан хотын захирагч, Онцгой комиссын гишүүн О.Пүрэв-Очир нарт:

1.6.Хэрлэн сумын 6 дугаар багийн нутаг хуучин Авто тээврийн төвийн талбайд иргэдэд үйлчлэх дархлаажуулалтын цэгийг нэмэгдүүлэх,

Хоёр.Эрүүл мэндийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн Ч.Оюунаа-д:


2.1. 55 наснаас дээш насны иргэдэд дархлаа сэргээх нэмэлт тун буюу 3 дугаар тун хийхэд шаардагдах Файзер үйлдвэрийн 6000 хүн тун вакциныг 14 сумдад хуваарилан олгох,

Гурав.Боловсрол, соёл урлагийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн А.Нансалмаа,

Аймгийн ерөнхий тархвар судлаач, Онцгой комиссын гишүүн Б.Ганганцэцэг,

Сумдын Засаг дарга, Онцгой комиссын дарга Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн захирал эрхлэгч нарт:

3.1.Өвчлөл бүртгэгдсэн тохиолдолд сургууль, цэцэрлэгийн удирдлага нь Боловсрол, соёл урлагийн газар, аймгийн ерөнхий тархвар судлаач, эцэг эхчүүдтэй санал солилцож сумын Онцгой комиссын хуралд асуудлыг танилцуулж шийдвэрлүүлэх,

 / М.Бадамсүрэн  
/ х/ч Б.Цогтбаяр



Эрүүл мэндийн газрын дарга, Онцгой комиссын  
гишүүн Ч.Оюунаа,  
Аймгийн Ерөнхий тархвар судлаач, Онцгой комиссын  
гишүүн Б.Ганганцэцэг нарт:

3.2.Коронавируст халдвар (Ковид-19)-ын цар тахалтай тэмцэх зөвлөмжийг сумын Засаг дарга, Онцгой комиссын дарга нарт албан бичгээр чиглэл хүргүүлэх,

Дөрөв.Сумын Засаг дарга, Онцгой комиссын  
дарга нарт:

4.1.Үхрийн арьс товруутах өвчний шинж тэмдэг илрүүлэх чиглэлээр хонь, ямаанд тандалтыг зохион байгуулах,

Мал эмнэлгийн газрын дарга, Онцгой комиссын  
гишүүн Ч.Аюушмаа,  
Тагнуулын газрын дарга, Онцгой комиссын  
гишүүн, хурандаа Б.Бямбаа нарт

4.2.Зарим сумдад малын гоц халдварт өвчин гарсантай холбогдуулан авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар сумын Засаг дарга, Онцгой комиссын дарга нарт албан бичгээр чиглэл хүргүүлэх,

Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга,  
Онцгой комиссын гишүүн П.Бат-Өлзий-д:

4.3.Сумын Засаг дарга, Онцгой комиссын дарга нар ээлжийн амралт болон эрүүл мэндийн шалтгаантай ажилдаа орох боломжгүй байгаа тохиолдолд Засаг даргын эрхийг захирамжаар шилжүүлэх талаар сумын Засаг дарга, Онцгой комиссын дарга нар чиглэл хүргүүлэх,

Сумын Засаг дарга, Онцгой комиссын  
дарга нарт:

4.4.Коронавируст халдвар (Ковид-19)-ын цар тахал болон үхрийн арьс товруутах өвчний нөхцөл байдалтай уялдуулан хариу арга хэмжээг шуурхай авч хэрэгжүүлэхэд анхаарч ажиллах,

Мал эмнэлгийн газрын дарга, Онцгой комиссын  
гишүүн Ч.Аюушмаа-д:

4.5.Үхрийн арьс товруутах өвчин гарсан сум, багуудад 60 хоногийн хугацаатай хорио цээрийн дэглэмийг 20 км-ын радиустай тогтоож хяналт тавьж ажиллах,

Аймгийн Засаг даргын орлогч, Онцгой комиссын  
орлогч дарга Ч.Ганбат,  
Мал эмнэлгийн газрын дарга, Онцгой комиссын  
гишүүн Ч.Аюушмаа,  
Тагнуулын газрын дарга, Онцгой комиссын  
гишүүн, хурандаа Б.Бямбаа,

/ / М.Бадамсүрэн  
/ / х/ч Б.Цогтбаяр



Эрүүл мэндийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн Ч.Оюунаа,  
Цагдаагийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн, цагдаагийн хурандаа Т.Ганзориг,  
Мэргэжлийн хяналтын газрын дарга, Онцгой комиссын гишүүн Д.Мөнхтуяа нарт:

4.6.Мал эмнэлгийн газар, Эрүүл мэндийн газар, Мэргэжлийн хяналтын газар, Цагдаагийн газар, Тагнуулын газар болон мэргэжлийн байгууллагын бүрэлдэхүүнтэй ажлын хэсгүүдийг байгуулах, сумдад үүссэн үхрийн арьс товруутах өвчин болон коронавируст халдвар (Ковид-19)-ын цар тахлын нөхцөл байдалтай газар дээр нь танилцах чиглэлээр томилж ажиллуулах,

Тав.Аймгийн Засаг даргын зөвлөх, Онцгой комиссын гишүүн Х.Энх-Отгон-д:

5.1.Сумдад гарсан үхрийн арьс товруутах өвчин болон цагаан зээрийн олноор хорогдож байгаа талаар мэргэжлийн байгууллага, сумын Онцгой комиссоос холбогдох мэдээлэл, судалгааг авч анализ хийж дүгнэлтийг аймгийн Засаг дарга, Онцгой комиссын даргад танилцуулах,

Зургаа.Гаалийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн Б.Гэрэлт-Од-д:

6.1.Иргэн А.Ерөөлтөөс аймгийн Онцгой комисст ирүүлсэн “БНХАУ-аас өөрийн эзэмшлийн тээврийн хэрэгслийг Баянхошуу боомтоор нэвтрүүлэх тухай” хүсэлтийг хариуг Улсын Онцгой комиссоос өгсөн чиглэлийн дагуу мэдэгдэх,

Бүсийн төв Онцгой байдлын газрын дарга, Онцгой комиссын орлогч дарга, хурандаа Г.Нармандах-д:


6.2.“Нийтийг хамарсан арга хэмжээг хязгаарлах тухай” аймгийн Онцгой комиссын тогтоолын төсөлд гишүүдийн саналыг тусгаж батлуулах,

6.3.Зам тээврийн хөгжлийн яамны Далайн захиргаанаас аймгийн Онцгой комисст ирүүлсэн албан бичгийн дагуу Байгаль орчин, аялал жуулчлалын газар, Цагдаагийн газар, сумдын Засаг даргын Тамгын газар болон мэргэжлийн байгууллагуудад албан бичгийг хүргүүлж хийсэн ажлын тайланг хүлээн авч хариуг хүргүүлэх,

6.4.“Эрдэнэдриллийн” ХХК-аас аймгийн Онцгой комисст ирүүлсэн хүсэлтийн дагуу тус компанийн ажилчдыг шаардлага хангасан тусгаарлах байранд тусгаарлах, шинжилгээг өгөх талаар зохих хариуг хүргүүлэх,

АЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга, Онцгой комиссын гишүүн В.Цэнгэлмаа-д:

6.5.Чулуунхороот сумын Онцгой комиссоос аймгийн Онцгой комисст ирүүлсэн “Зөөврийн сууц ашигласан тухай” албан бичгийг судалж зохих саналыг аймгийн Онцгой комиссын дараагийн хуралд танилцуулах,

 / М.Бадамсүрэн  
Тх/ч Б.Цогтбаяр



Мэргэжлийн хяналтын газрын дарга, Онцгой комиссын  
гишүүн Д.Мөнхтуяа,  
Эрүүл мэндийн газрын дарга, Онцгой комиссын  
гишүүн Ч.Оюунаа,  
Цагдаагийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн,  
цагдаагийн хурандаа Т.Ганзориг нарт:

6.6.Петрочайна дачин тамсаг ХХК-аас аймгийн Онцгой комисст ирүүлсэн “Малчид, хувиараа хөдөлмөр эрхэлж буй иргэдэд хяналт тавих тухай” хүсэлтийн дагуу мэргэжлийн байгууллагууд хамтран хяналт тавих талаар санал танилцуулах,

Мэргэжлийн хяналтын газрын дарга, Онцгой комиссын  
гишүүн Д.Мөнхтуяа-д:

6.7.“Мөрөөдлийн ордон” тоглоомын төвөөс аймгийн Онцгой комисст ирүүлсэн хүсэлтийн дагуу 30 хувиас илүүгүй дүүргэлтэй, халдвар хамгааллын дэглэмийг мөрдүүлэн үйл ажиллагааг эхлүүлэхийг зөвшөөрөв,

6.8.“Шинь шинь” ХХК-аас аймгийн Онцгой комисст ирүүлсэн хүсэлтийн дагуу ариутгал халдваргүйтгэлийг мэргэжлийн байгууллагаар хийлгэхэд хяналт тавьж ажиллах, ээлжээр ажилладаг албан хаагч нарыг тусгаарлах, тусгаарлах байрны хяналтыг сайжруулах талаар зөвлөмж өгч ажиллахыг тус тус үүрэг болгов.

ДАРГА

М.БАДАМСҮРЭН